



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар A-56

Улаанбаатар хот

"Аргай Бэст ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын А-31 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Аргай Бэст ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан "Гишүүнчлэлийн гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Аргай Бэст ҮЦК" ХХК /Э.Болормаа/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт, шинжилгээний алба /Д.Баттулга/-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ